

Социализмын материал техникийн бааз бүрэн байгуулахын өмнөх үе шатанд улс ардын аж ахуйн бүх салбарт социалист харилцааг бэхжүүлсэн нь БНМАУ дахь шилжилтийн үеийн онцлог юм. Энэ нь улс орны эдийн засгийн хүч чадал өссөн, түүнчлэн үйлдвэрлэх хүчний хоцрогдлыг нэлээд хэмжээгээр нөхөх гэж социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай бүх талаар хамтран ажилласны үрээр бололцоотой болсон байна.

Капитализмын өмнөх харилцаанаас социализмд шилжих үед шинэ нийгмийн материал техникийн бааз байгуулах нь онцгой төвөгтэй, олон талт, урт удаан хугацааны үйл явц бөгөөд энэ үйл явц дуусах үед шилжилтийн үеийн хүрээнээс давж болох юм гэдгийг туршлага гэрчилж байна.

Социализмын материал техникийн зүй зохистой цогцолборыг байгуулж дуусгах нь БНМАУ-ын социалист хөгжлийн өнөө үеийн эдийн засгийн гол асуудал болж байна.

Орос хэлнээс орчуулсан **Л. БЭГЗЖАВ**

ХЯТАДЫН ДАЛАЙН ЭРГИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ

С. Жаргалсайхан

Марксизмыг үндэслэгчид «урьд орон нутаг, үндэсний талаар битүү түгжүү байж өөрийнхөө үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр амьдарч байсны оронд, улс үндэстэн тал тал тийшээ хэлхээтэй болж, бие биетэйгээ зүйл зүйлийн холбогдолтой болж ирэв»¹ хэмээн одоогоос 140 гаруй жилийн өмнө бичиж байжээ. Ухаант мэргэдийн энэхүү дүгнэлт улс түмний өнөө цагийн байдалтай яв цав нийцэж, эдүгээ дэлхийн олон улс орон хэзээ хэзээнийхээс илүү «бие биетэйгээ зүйл зүйлийн холбогдолтой болж ирэв. Дэлхийн улс түмэн нягт харилцаа холбоотой болсны учир юун хэмээвээс цөмийн дайны аюулыг зайлуулах асуудал амин чухал болж, шинжлэх ухаан, техникийн хувьсгал гүнзгийрч, үйлдвэрлэх хүч улам бүр олон улсын шинж чанартай болж, байгаль

1. В. И. Ленин. ПСС, т 43, с, 199 (В, И, Ленин зохиолууд 32-р боть, УБ, 1967, 321-р тал орч).
2. В. И. Ленин. ПСС, т, 43, с. 228 (В, И, Ленин зохиолууд 32-р боть, УБ, 1967, 355-р тал орч).
3. 50 лет МНР с. 63
4. Народное хозяйство МНР за, 65 лет (1921—1986) Юбилейный статический сборник, УБ., 1986, с. 100, 101
5. Мөн Тэнд, с. 110, 111
6. Мөн тэнд. с. 127, 128
7. 50 лет МНР с. 196
8. В. И, Ленин. Псс, т, 43, с, 206 (В, И, Ленин зохиолууд, 32-р боть, УБ 1967, 334-р тал)
9. XV съезд Монгольской народно-революционной партии М., 1966, с. 175, 177
«За № 45»

орчин бохирдож, түүхий эдийн нөөц хомсдож байгаагийнх болой. Эдүгээ цагийн дэлхий ертөнц дэх нийгмийн байгуулал өөр өөр улс орнууд эдийн засгийн талаар улам их харилцан хамааралтай болоод байна. Улс орон бүр аж ахуйн салаа мөчир бүртээ шинэчлэлт өөрчлөлт хийж, гадаад орнууд лугаа өргөн дэлгэр харилцах боллоо.

Дэлхийн хөгжлийн энэхүү ерөнхий хандлагаас Хятад орон үлдэж хоцорсонгүй. Хятадын удирдлага улс орныхоо өвөрмөц байдалд тохируулан эдийн засгийн шинэчлэлт хийх, гадаад орнуудтай өргөн харилцах нээлттэй бодлогыг хэрэгжүүлж байна.

1978 оны 12 дугаар сарын 18—22-нд Бээжин хотноо хуралдсан ХКН-ын Төв Хорооны III бүгд хурлаас дээрх бодлогыг боловсруулан гаргасан. Тус бүгд хурлын албан мэдээнд «...өөрийн хүчээр хөгжих үндсэн дээр дэлхийн олон улстай эрх тэгш, харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж, дэлхийн тэргүүний техник, тоног төхөөрөмжийг ашиглаж байх бөгөөд шинэчлэлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах шинжлэх ухаан, боловсролын ажлыг ихээхэн бэхжүүлж байна. Иймээс манай аж ахуйн байгуулалт дахин өндөр хурдацтай, тогтвортой урагшлан хөгжих нь эргэлзээгүй юм»² гэжээ.

Нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх, дэлхийн улс орнуудтай эдийн засгийн талаар хамтран ажиллах үндсэн гол арга зам бол тусгай бүс, хотыг гадаадынханд нээлттэй болгох явдал гэж хятадын удирдлага үзсэн байна. Энэхүү бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхдээ улс орнуудын гадаад худалдаа, нээлттэй бүсүүдийн туршлагыг харгалзан үзжээ. 1985 оны байдлаар дэлхийд эдийн засгийн онцгой бүс 400 орчим³ байв. Эдгээр бүс нь чөлөөт боомт, чөлөөт худалдааны бүс, гадаад худалдааны бүс, гаалийн чөлөөт бүс, хөрөнгө оруулахад туслах бүс хэмээсэн өөр өөр нэр хаягтай байдаг.

Хятадын удирдлага энэхүү бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эдийн засгийн дорнод муж буюу далайн эргийн бүс нутгаас эхэлсэн юм. Хятад орныг эдийн засгийн гурван мужид хуваадаг. Үүнд: **Баруун мужид**, Сычуань, Гуйжоу, Юннань, Төвд, Шэньси, Ганьсу, Цинхай, Нинься, Синьзянь, **Төв мужид**, Шаньси, Өвөр Монгол, Зилинь, Хэйлунзянь, Аньхуй, Зяньси, Хэнань, Хубэй, Хунань, **Дорнод мужид**, Хэбэй, Ляо Нинь, Шанхай, Зяньсу, Жэзянь, Фузянь, Шандун, Гуандун, Гуанси, Бээжин, Тяньзинь зэрэг хот, муж, өөртөө засах орон ордог.

Чухам юуны учир дорнод муж буюу далайн эргийн бүс нутгаас эхэлж нээлттэй бодлогыг хэрэгжүүлэх болов?

Энэ бүс нутаг нь эрэг дагуу 18000 км урт агаад 70 гаруй боомт хоттой.⁴ Далайн эргийн бүс нутагт 200 сая хүн ам оршин суудаг бөгөөд жилдээ 1000 миллиард юаний өртөгтэй аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг.⁵ Мөн энэ бүсийн муж, хотуудад хятадын аж үйлдвэрийн 60-аас илүү хувь төвлөрсөн байдаг.⁶

Өөрөөр хэлбэл энэ бүс нь эдийн засгийн баруун болон төв мужийг бодвол хүн ам олон учир ажиллах хүчний нөөцтэй, газар зүйн байрлал тохиромжтой тул зам тээвэр, харилцаа холбооны хувьд боломжтой, аж үйлдвэрийн суурь сайтай, таваарын аж ахуй илүү хөгжсөн зэрэг давуу талтай юм. Үүнээс гадна байгалийн баялаг, эрчим

хүчний хувьд бололцоотой, арилжаа наймаа хийх, гадаадтай харилцах дадлага туршлагатай гэж үздэг байна. Энэ бүхнийг үндэслэн нээлттэй бодлогыг далайн эргийн бүс нутгаас эхэлсэн байна.

ХКН-ын Төв Хороо 1979 оны 7 дугаар сарын 15-нд Гуандун, Фузянь мужийн гадаад эдийн засгийн үйл ажиллагаанд «онцгой бодлого, уян хатан арга хэмжээ» авч хэрэгжүүлэх шийдвэр гаргаснаар нээлттэй бодлогыг бодит ажил болгосон болой. Үүний дагуу БХАТИХ-ын Байнгын хороо 1980 оны 8 дугаар сарын 26-ны хуралдаанаараа Гуандун мужийн Шэньжэнь, Жухай, Шаньтоу хотыг, мөн оны 10 дугаар сард Төрийн зөвлөлийн зөвшөөрлөөр Фузянь мужийн Сяомэнь хотыг эдийн засгийн онцгой бүс (ЭЗОБ) хэмээн албан ёсоор зарласан билээ.

ХКН-ын Төв Хороо, Төрийн зөвлөл 1984 онд далайн эргийн 14 боомт хот (Далаянь, Тяньзинь, Яньтай, Циндао, Лэньюньган, Наньтон, Шанхай, Нинбо, Вэньжоу, Фужуо, Гуанжоу, Канзянь, Бэйхай, Цинхуандао), Хайнань арлыг нээлттэй болгов.

Мөн 1985 онд Төрийн зөвлөл Гуандун муж дахь Жузянь, Фузянь муж дахь Минзянь, Зяньсу муж дахь Чанзянь мөрний бэлчир нутгийг эдийн засгийн нээлттэй бүс болгов. Үүний хойно Шандун, Ляодуны хойгийг эдийн засгийн нээлттэй бүс болгож, өнгөрөгч оны 4 дүгээр сард Хайнань арлыг бие даасан муж, эдийн засгийн онцгой бүс болгосон.

Одоо далайн эргийн дагуу оршдог эдийн засгийн онцгой бүс, Нээлттэй хотууд, эдийн засгийн нээлттэй бүсийн талаар товчхон өгүүлье.

ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦГОЙ БҮС

Шэньжэнь нь Гуандун мужийн өмнөд захад орших 327,5 хав. дөр. км газар нутагтай. Гадаадын хөрөнгийг ихээр оруулж ашиглахын тул юуны өмнө эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд нэлээд анхаарч, 200 гаруй км зам засч, шинээр 3 боомт нээж, Наньтоу дахь нисдэг тэрэгний буудал барьж, хил нэвтрэх 5 боомт нээж, 700,000 киловаттын хүч чадалтай цахилгаан станц шинээр барьснаас гадна, харилцаа холбооны барилга байгууламж, техникийг шинэчилсний дүнд дотоодын 90 гаруй хот, АНУ, Япон, Сингапур, Гонконг зэрэг 10 гаруй улс, бүс нутагтай шууд ярих болжээ. Шэньжэний гадаад худалдаа өргөжсөөр байна. 1985 онд 880 сая юаний бүтээгдэхүүн гадаадад гаргаж байсан бол 1986 онд 1 миллиард 819 сая юаний, 1987 онд 3 миллиард 70 сая юаний бүтээгдэхүүн гаргажээ. 1987 онд 4 миллиард 620 сая америк долларын гадаад хөрөнгө оруулах 5517 гэрээ хэлэлцээр байгуулж, 1 миллиард 890 сая долларын хөрөнгийг бодитойгоор ашиглажээ. Одоо Шэньжэньд хятад, гадаадын хамтарсан, хоршсон, гадаадынхан дангаар барьсан үйлдвэрийн газар 1400 гаруй болжээ.⁷

Шэньжэний нийгмийн нийт бүтээгдэхүүний хэмжээ 1986 онд 1979 оныхоос 25, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 21, үндэсний орлого 16 дахин нэмэгджээ.⁸ Шэньжэньд аялал жуулчлал, олон улсын худалдаа, аж үйлдвэр, нефть боловсруулах үйлдвэрийг голлон хөгжүүлж байна.

Шаньтоу нь Гуандун мужийн зүүн өмнөд талд орших бөгөөд анх 1,62 хав, дөр.км газар нутгийг ЭЗОБ болгосон бол 1984 оны 11 дү-

гээр сарын 29-нд 52,6 хав, дөр. км болгон өргөтгөжээ. Энэ бүсэд 1988 оны эхний 10 сард гадаадын хөрөнгө оруулах 69 гэрээ байгуулж, хамтарсан үйлдвэр 28, хоршсон үйлдвэр 13, гадаадынхан дагнасан үйлдвэр 21-ийг байгуулжээ. 1988 оны эхний 10 сард аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 450 сая юань болсон нь урьд оныхоо мөн үеийнхээс 83,7 хувиар нэмэгдсэн байна.»⁹ Энэ бүсэд аялал жуулчлал, худалдаа, хөнгөн, хүнсний үйлдвэрийг голлон хөгжүүлж байна.

Сяомэнь бол Фузянь мужийн өмнөд талд оршдог. Анх 2,5 хав. дөр. км нутаг дэвсгэрийг ЭЗОБ-ээр зарласан бол 1985 оны 6 дугаар сараас 131 хав. дөр. км болгож өргөтгөсөн байна. Сяомэний аж үйлдвэр хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 1987 онд 1981 оныхоос 2 дахин, санхүүгийн орлого нь 2,5 дахин өсчээ. Агаарын шугам 16-г шинээр нээсэн бөгөөд долоо хоног тутам 70 шахам нислэгийн баг хүлээн авах боломжтой болсны гадна дотоодын 119 хот, гадаадын 18 улс, бүстэй шууд ярих болжээ. Энэ бүсийн зорилго нь 1990 он гэхэд үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээг 5 миллиард юань, 1995 онд 10 миллиард юанд хүргэж, энэ зууны эцэст аж үйлдвэр, шинжлэх ухаан, техникийн тэргүүний хөгжилтэй бүс болгох юм байна.¹⁰

Хайнань арлыг 1988 оны 4 дүгээр сард ЭЗОБ болгон зарласан билээ. Энэ арал нь эх газраас 18 км зайтай орших бөгөөд 34,290 хав. дөр. км газар нутагтай, 6,05 сая хүн амтай.¹¹ Жилийн дундаж дулаан нь 22-26 хэм, 2000 мм-ийн хур тунадас унадаг. Төмөр, титан, нүүрс, шохойн чулуу, бал чулуу, сүүмэг зэрэг 30 гаруй нэрийн эрдэс чулуулгаар баялаг юм. Шилоу дахь төмрийн уурхай Азид томоохонд ордог бөгөөд түүний нөөц нь 260 сая тонн ажээ.¹² Хайнань нь Хятадын үйлдвэрлэн гаргадаг каучукийн 60 хувь, хар перецийн тэн хагасыг гаргадаг байна. 1988 оны 8 дугаар сард хуралдсан Хайнань мужийн ардын хурлын анхдугаар чуулганаар Су Шизяг (68 настай, Гуанжоу мужийн намын хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан) мужийн их хурлын даргаар, Лян Сянийг (69 настай, Шэньмэнь хотын даргаар ажиллаж байсан) мужийн даргаар тус тус сонгожээ.

Лян Сян мужийнхаа хөгжлийн үе шатыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд: 3—5 жилд эдийн засгийн хөгжлийн хувьд улсын дундаж түвшинд хүрч, хүн амаа ахуйн зохих зүйлээр хангах, 5-7 жилд эх газрын илүү хөгжилтэй бүс нутгийн түвшинд хүрэх, дараагийн 10 жилд хүн амд оногдох нийт бүтээгдэхүүний хэмжээг 2000 долларт хүргэх ажээ.¹³

Төлөвлөгөө ёсоор тус бүсийг эдийн засгийн 5 дэд бүсэд хувааж хөгжүүлэх юм байна.

Хайкоу хотоор төвлөсөн хойд бүсд хөнгөн ба хүнсний үйлдвэр, каучук, машин, электроникийн үйлдвэр, **Санягаар төвлөсөн өмнөд бүсд** аялал жуулчлал, өндөр техникийн үйлдвэр, **Цянхай Вэнчанаар төвлөсөн дорнод бүсд** хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэр, хөнгөн ба хүнс, сүлжмэлийн үйлдвэр, **Надягаар төвлөсөн баруун хойд бүсд** титан, усны үйлдвэр, нефтиэс гарах химийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, **Басус хотоор төвлөсөн баруун өмнөд бүсд** ган, төмөр, цемент зэрэг хүнд үйлдвэрийг голлон хөгжүүлэх юм байна.¹⁴

Тоо бүртгэлийн мэдээнээс үзвэл, 1987 онд Шэньжэнь, Жухай, Шаньтоу, Сяомэнь энэ 4 ЭЗОБ-ийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн-

ний хэмжээ 11 миллиард 200 сая юань болсон нь урьд оныхоосоо 52 хувь, гадаадад гаргасан бүтээгдэхүүний хэмжээ 2 миллиард 74(0) сая доллар болсон нь 1986 оныхоос 114 хувь өсчээ. 1987 онд бодитойгоор ашигласан гадаадын хөрөнгө 510 сая доллар болсон нь урьд оныхоос 16 хувиар буурсан байна.¹⁵ 1988 онд энэ 4 ЭЗОБ-ийн гадаадын хөрөнгөөр барьсан үйлдвэрийн гадаадад гаргасан бүтээгдэхүүний хэмжээ 1 миллиард 20 сая доллар болсон нь улсын хэмжээний тэр төрлийн үйлдвэрээс гаргасан экспортын бүтээгдэхүүний 42 хувийг эзэлж байна.¹⁶

ДАЛАЙН ЭРГИЙН БООМТ ХОТУУД

Далайн эргийн 70 гаруй боомт хотоос 14-ийг нь гадаадад нээлттэй болгосон тухай өмнө цухас тэмдэглэсэн билээ. Эдгээр 14 хотод Хятадын хүн амын 7,7 хувь оршин сууж, улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 25 хувийг үйлдвэрлэдэг бөгөөд түүнээс хятадын аж үйлдвэрийн ашиг орлогын 25 хувийг олдог байна. Эдгээр хотод хятадын дээд, дунд сургуулийн 12 хувь, 17 хувь нь тус тус байдаг ажээ.¹⁷

1986 онд эдгээр хот нь 199,2 миллиард юаний аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 1985 оныхоос 7,4 хувь илүү байв. Мөн онд 1,26 миллиард долларын гадаад хөрөнгө оруулах, 2741 гэрээ, хэлэлцээр байгуулж, 320 сая долларын хөрөнгө ашигласан нь урьд оныхоос 13,3 хувиар өссөн бол¹⁸ 1988 оны эхний 3 улиралд гадаадын хөрөнгө оруулах 1860 гэрээ байгуулсан нь 1987 оны мөн үеийнхээс 115 хувиар илүү байна.

Эдгээр хот нь хүн амын тоо, аж үйлдвэржилтээр хятадын бусад хотоос хол давуу юм. Тухайлбал 12 сая хүн амтай, 6000 хав, дөр. км газар нутагтай Шанхай хот хятадын аж үйлдвэр, эдийн засгийн том төв билээ. Тус хотод гадаад бүтээгдэхүүн гаргахад чиглэсэн 140 үйлдвэр ажилладаг бөгөөд энэ хот дэлхийн 160 улстай худалдааны харилцаатай байна. Шанхайн дараа орох боомт хот Далянь нь 4,7 сая хүн амтай, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ нь 10 миллиард юаниас давсан улсын хэмжээний 16 том хотын нэг билээ.

ЭДИЙН ЗАСГИЙН НЭЭЛТТЭЙ БҮС

Гуандун мужийн **Жузянь**, Зяньсу мужийн **Чанзянь**, Фузянь мужийн **Минзянь** мөрний бэлчир нутгийг эдийн засгийн нээлттэй бүс болгосон. Жузяний бэлчир нутаг нь 22,700 хав, дөр. км нутагтай, 10,27 сая хүн амтай, Гуанжоу, Фошан, Шэньжэнь, Зяньминь, Жухай зэрэг 40 гаруй хоттой. Чанзяний бүс нь Сужоу, Уси, Чанжоу зэрэг 3 хот, 12 сяньтай, 17, 513 хав, дөр. км нутагтай, 12,6 сая хүн амтай. Эдгээр гурван бэлчир нутагт бүтээгдэхүүнээ гадаадад гаргахад чиглэсэн газар тариалангийн үйлдвэрлэл хөгжүүлж байна. Үүнтэй уялдаж нэхмэл, хүнс, нийлэг эд, хуванцар боловсруулах үйлдвэрийг хөгжүүлж байна.

Ляодуны хойг нь 54,210 хав, дөр. км газар нутагтай, 21,5 сая хүн амтай, 110 гаруй нэрийн эрдэс түүхий эдтэй. 1987 онд хойгийн аж үйлдвэр, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 74,12 миллиард юань болжээ. Хойгийн хэмжээгээр жилдээ байгалийн нефть, түүхий

төвөр, ган, цемент тус бүр 10 сая тонныг үйлдвэрлэдэг байна.¹⁹ Энэ хойгт Инкоу, Далянь, Даяован зэрэг аж үйлдвэрийн том том хот байдаг билээ.

Шандуны хойг нь Циндао, Яньтай зэрэг 7 хот, 44 сяньтай, 50,000 хав, дөр. км газар нутагтай. Энэ хойгийг эдийн засгийн нээлттэй бүс болгох Төрийн Зөвлөлийн шийдвэр гарсны дараа Шандун мужийн засгийн газар гадаадад гаргах бүтээгдэхүүнийг боловсруулан үйлдвэрлэх бүс байгуулах, гадаад хөрөнгө ашиглаж хуучин үйлдвэрээ шинэчлэх, гүйлгээний зах нээх зэрэг хэд хэдэн арга хэмжээ авч эхэлжээ.

* * *

Бидний дээр өгүүлсэн эдийн засгийн онцгой бүс, эдийн засгийн нээлттэй бүс, нээлттэй хотууд нь гадаадтай харилцах түшиц газар болж, үүд хаалгын үүрэг гүйцэтгэж байна²⁰ гэж хэлсэн билээ. Далайн эргийн бүс нутгаас эхэлж хэрэгжүүлсэн нээлттэй бодлогын дүнд дэлхийн улс орнуудын шинжлэх ухаан, техникийн тэргүүний ололт, амжилт, мэдлэг чадвар, аж ахуйг эрхлэн хөтлөх дэвшилтэт, үр өгөөжтэй арга барил, гадаадын их хэмжээний хөрөнгийг оруулан ашиглах боллоо. Эдийн засгийн шинэчлэлт, нээлттэй бодлогын үрээр Хятадын эдийн засаг, ялангуяа гадаад худалдаа хөгжсөөр байна. Тухайлбал, өнгөрсөн 10 жилд экспорт, импортын хэмжээ 500 миллиард долларт хүрсний дотор экспорт 249 миллиард доллар, импорт 256 миллиард 200 сая доллар болжээ. Одоо улсын хэмжээгээр хятад, гадаадын хамтарсан, хоршсон, гадаадынхан дагнасан 15898 үйлдвэр²¹ барихыг зөвшөөрснөөс 7000 орчим нь ашиглалтад оржээ. Өнгөрсөн 1988 онд экспорт, импортын хэмжээ 102 миллиард 900 сая доллар болсон нь²² 1978 оныхоос 2,8 дахин өссөн байна. 1988 онд Хятадын эдийн засгийн өсөлт 8,5 хувьд хүрчээ.²³

Энэ бүхнээс үзэхэд далайн эргийн бүс нутаг нь эдийн засгийн гадаад харилцаанд төдийгүй хятадын эдийн засагт шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болов.

ХКН-ын XIII их хурлын улс төрийн тайлан илтгэлд «Өнөөгийн дэлхий ертөнц нь өргөн харилцааны дэлхий ертөнц билээ. Гадаад харилцаагаа өргөжүүлэх төрийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх талаар бид асар их амжилт олсон. Цаашид дэлхийн эдийн засгийн үйл ажиллагаанд улам зоримог орох, импорт, экспортын болон гадаадын хөрөнгийг ашиглах стратегийг зөв сонгох, дэлхийн хөгжингүй, хөгжиж байгаа зэрэг бүх улс оронтой техник, эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны солилцоог улам өргөжүүлэх, улс орныхоо шинжлэх ухаан, техникийн дэвшлийг түргэтгэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх тааламжтай нөхцөл бүрдүүлэх зорилт бидний өмнө тулгарч байна»²⁴ гэж онцлон тэмдэглэсэн. Энэхүү стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд далайн эргийн бүс нутаг онц чухал үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй юм. Ийм учраас ХКН-ын Төв Хороо, БНХАУ ын Төрийн зөвлөл далайн эргийн бүс нутагт гадаадад чиглэсэн аж ахуйг хөгжүүлэн бэхжүүлэх чиг шугамыг боловсруулан хэрэгжүүлж байна. Энэ чиг шугамын гол агуулга нь далайн эргийн бүс нутагт гадаадад гаргах бүтээгдэхүүн боловсруулан үйлдвэрлэж, улмаар дэлхийн зах зээлд идэвхтэй оролцож ашиг олоход оршино.

Үүний тул дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагын дагуу үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, техникийн бүтцээ өөрчилж байх шаардлагатай гэж Хятадын эдийн засагчид үзэж байгаа юм. Далайн эргийн бүс нутгийн хөгжлийн туршлагаас үүдэн гадаадад чиглэсэн аж ахуйг хөгжүүлэхдээ аж үйлдвэр-худалдаа, газар тариалан-худалдаа, аж үйлдвэр-газар тариалан-худалдаа гэсэн үйлдвэрлэлийн системийг хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Гэхдээ гадаад худалдааг голлох шаардлагатай гэдэгт Хятадын эдийн засагчдын санал нэг байна.

Далайн эргийн бүс нутаг нь дотроо газар зүйн байрлал, байгалийн баялаг, үйлдвэржилт, шинжлэх ухаан, соёлын байдлаараа харилцан адилгүй тул гадаадад чиглэсэн аж ахуйг нэг хэв загвараар буюу захиргааны аргаар эрхлэн хөтөлж болохгүй, харин тухайн нутгийн нөхцөл байдалд тохируулан хөгжүүлэх хэрэгтэйг эдийн засагчид анхааруулж байна.

Гадаадад чиглэсэн аж ахуйн хөгжилд байгалийн баялаг, түүхий эдээр баян дотоод газар, техникийн давуу талтай далайн эргийн бүс нутгийн хоорондын уялдаа холбоо, мөн энэ бүсийн хоорондын харилцааг их чухал үүрэгтэйд тооцож байна.

Гадаадад чиглэсэн аж ахуйг хөгжүүлэх асуудал үндсэн хэд хэдэн бэрхшээлтэй тулгарч байна. Үүнд хятадын эдийн засгийн шинэ, хуучин системийн зөрчил, гадаад худалдааны шинэчлэлт шинэ шаардлагаас хоцрогдонгуй байгаа явдал, эдийн засгийн гадаад харилцааны холбогдолтой хууль эрхийн баримт дутагдалтай зэрэг бэрхшээл орж байгаа юм.

Далайн эргийн бүс нутгийн эдийн засгийн хөгжил хэдийгээр бэрхшээл зөрчилтэй байгаа боловч гадаадын их хэмжээний хөрөнгө оруулж, хуучин үйлдвэрээ шинэчлэх, шинийг барих зэрэг тогтсон байдлаас Дэлхийд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд идэвхтэй оролцох, тэндээс түүхий эд олох зорилготой идэвхтэй чиглэл рүү эргэж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

1. К. Маркс, Ф. Энгельс. Түүвэр зохиол 1 боть, УБ, 1969 он, 114-р тал
2. «Жэньминь жибао» 1978, ХП. 24
3. «Dui wai kaijan zisun shou ce» Beijing. 1987, p, 378
4. «Issues and studies» 1988. № 12
5. «Жэньминь жибао» 1988, XI, 4
6. «Жэньминь жибао» 1988, IV. 8
7. «Гуанминь жибао» 1988. V. 2
8. «Хунци» 1987 № 20
9. «China daily. Business weekly» 1989. 1. 23
10. «Хунци» 1988 % 3
11. «China reconstructs» 1988 No 12
12. «Beijing review» 1988 No 12
- 13 «China reconstructs» 1988 No 12
14. Мөн тэнд
15. «Гуанм'инь жибао» 1988. П. 25
16. «Жэньминь жибао» 1989, II, 9
- 17 «Issues and studies» 1988. No 12
18. «Beijing review» 1987 13
19. «Beijing review » 1988 N 33 ;
20. «Жэньминь жибао» 1984, XI, 26
21. «Вэньхуй бар» 1989. 1. 24
22. «Жэньминь жибао, 1989. 1. 19
23. «Жэньминь жибао» 1981, 1, 2
24. «Документы XII Всекитайского съезда КПК». Пекин, 1987. с, 29